



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ТӨВИЙН  
2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2026/29/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



**Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Аудитор Г.Золбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: Zolbayarg@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2026 он

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>5</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....</b>	<b>8</b>
<b>5.3 Зөвлөмж .....</b>	<b>8</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>10</b>

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ,ЗДНХөрөнгө	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.11 № 34

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД  
ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ТӨВИЙН  
ЗАХИРАЛ Ө.ОДБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацаанд төвлөрсөн орлогоос өмнөх онуудад хуримтлагдсан 37,815.4 мянган төгрөгийн ажиллагсадтай холбогдсон өглөгийг бүрэн барагдуулж, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Үндсэн үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлогоос төвлөрсөн нийт 147,035.2 мянган төгрөгийг ажилчдын цалин болон нийгмийн даатгалын шимтгэлд 92,027.4 мянган төгрөг, байр ашиглалт болон засвар үйлчилгээтэй холбоотой зардалд 46,351.2 мянган төгрөг, бусад урсгал зардалд 8,656.6 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

4526050039

## **Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв нь Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргатай байгуулсан 2025 оны 01 сарын 10-ны өдрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 96 хувиар дүгнүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>18,388,376.95</u></b>	<b><u>13,108,150.22</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b><u>11,041,916.95</u></b>	<b><u>3,488,236.22</u></b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	3,371,766.43	-
31110	Төгрөг	3,371,766.43	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b><u>7,670,150.52</u></b>	<b><u>3,488,236.22</u></b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	7,670,150.52	3,488,236.22
31213	Арилжааны банк дахь харилцах	7,670,150.52	3,488,236.22
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	<b><u>1,407,314.00</u></b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	1,407,314.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	1,407,314.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b><u>7,346,460.00</u></b>	<b><u>8,212,600.00</u></b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7,346,460.00	8,212,600.00
35410	Бичиг хэргийн материал	150,860.00	-
35420	Аж ахуйн материал	3,314,600.00	-
35470	Бусад хангамжийн материал	3,881,000.00	8,212,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>469,340,334.97</u></b>	<b><u>460,444,115.57</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b><u>469,340,334.97</u></b>	<b><u>469,444,115.57</u></b>
391	Газар	47,150,000.00	47,150,000.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	421,758,335.09	413,294,115.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	518,250,581.00	518,250,581.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(122,342,089.20)	(130,979,598.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,880,610.00	24,380,510.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,280,609.32)	(21,580,609.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,172,900.00	7,172,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,172,900.00)	(7,172,900.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,409,500.00	37,409,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,159,657.39)	(14,186,266.95)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	431,999.88	-
39301	Програм хангамж	50,480,000.00	50,480,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(50,048,000.12)	(50,480,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III+IV</b>	<b><u>487,728,711.92</u></b>	<b><u>473,552,265.79</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>37,815,436.08</u></b>	<b><u>37,815,436.08</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	37,815,436.08	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	37,815,436.08	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	37,815,436.08	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>449,913,275.84</u></b>	<b><u>473,552,265.79</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>449,913,275.84</u></b>	<b><u>473,552,265.79</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	446,650,000.00	446,650,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	446,650,000.00	446,650,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(104,219,805.16)	(80,580,815.21)
51210	Өмнөх үеийн үр дүн	(110,050,118.97)	(97,610,287.80)
51220	Тайлант үеийн үр дүн	5,830,313.81	17,029,472.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	107,483,081.00	107,483,081.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>487,728,711.92</u></b>	<b><u>473,552,265.79</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>95,901,034.00</b>	<b>148,453,175.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>95,901,034.00</b>	<b>148,453,175.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	95,901,034.00	148,453,175.38
120003	Торгуулийн орлого	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,901,034.00	148,453,175.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,701,034.00	126,981,523.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,200,000.00	21,524,000.00
120009	Бусад орлого		
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>90,070,720.19</b>	<b>131,423,702.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>90,070,720.19</b>	<b>131,423,702.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	90,070,720.19	131,423,702.79
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	44,957,460.48	54,134,389.76
210101	Үндсэн цалин	42,810,596.79	54,134,389.76
210102	Нэмэгдэл	2,146,863.69	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,135,232.40</b>	<b>6,687,127.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,135,232.40	4,649,017.91
210202	Тэтгэмжийн даатгал	-	472,111.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	236,055.63
210204	Ажилгүйдлийн даатгал	-	236,055.63
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,093,886.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,004,538.17</b>	<b>27,833,668.92</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,334,031.00	17,848,630.26
210302	Түлш, халаалт	4,311,049.30	6,367,233.62
210303	Цэвэр, бохир ус	5,359,457.87	3,617,805.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,926,777.26</b>	<b>7,470,000.00</b>
210401	Бичиг хэрэг	178,455.26	920,060.00
210402	Тээвэр, шатахуун	-	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	660,000.00
210404	Ном, хэвлэл	668,250.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,000.00	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,030,072.00	4,939,940.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,878,270.00</b>	<b>2,969,845.43</b>
210604	Урсгал засвар	1,878,270.00	2,969,845.43
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,492,543.00</b>	<b>18,517,552.24</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,049,000.00	17,865,890.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	224,443.00	594,000.00
210807	Газрын төлбөр	188,600.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,500.00	57,662.24
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,675,898.88</b>	<b>13,811,119.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,415,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,675,898.88	11,396,119.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>5,830,313.81</b>	<b>17,029,472.59</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>5,830,313.81</b>	<b>17,029,472.59</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>91,172,919.00</b>	<b>147,045,861.38</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>91,172,919.00</b>	<b>147,045,861.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	91,172,919.00	147,045,861.38
120003	Торгуулийн орлого	658,080.00	10,625.38
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	90,514,839.00	147,035,209.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73,314,839.00	125,511,209.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,200,000.00	21,524,000.00
120009	Бусад орлого		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>81,490,150.46</b>	<b>152,099,642.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>81,490,150.46</b>	<b>152,099,642.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>81,490,150.46</b>	<b>152,099,642.11</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	41,353,881.29	76,262,147.35
210101	Үндсэн цалин	39,853,881.29	76,262,147.35
210105	Гэрээт ажлын хөлс	1,500,000.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10,340,000.00	15,765,288.17
210201	Тэтгэврийн даатгал	10,340,000.00	13,727,179.04
210202	Тэтгэмжийн даатгал	-	472,111.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	236,055.63
210204	Ажилгүйдлийн даатгал	-	236,055.63
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,093,886.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18,465,324.17</b>	<b>27,833,668.92</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,794,817.00	17,848,630.26
210302	Түлш, халаалт	4,311,049.30	6,367,233.62
210303	Цэвэр, бохир ус	5,359,457.87	3,617,805.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,563,765.00	8,802,485.43
210401	Бичиг хэрэг	90,000.00	90,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	837,693.00	660,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, ариутгал	50,000.00	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,399,650.00	6,367,233.62
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,186,422.00	-
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,371,000.00</b>	<b>2,503,500.00</b>
210604	Урсгал засвар	4,371,000.00	2,503,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,368,100.00</b>	<b>18,517,552.24</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,999,000.00	17,865,890.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	594,000.00
210807	Газрын төлбөр	188,600.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	30,500.00	57,662.24
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,028,080.00</b>	<b>2,415,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,028,080.00	2,415,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>9,682,768.54</b>	<b>(5,053,780.73)</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>2,499,900.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<b>(2,499,900.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	9,682,768.54	<b>(7,553,680.73)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,359,148.41</b>	<b>11,041,916.95</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>11,041,916.95</b>	<b>3,488,236.22</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	<b>2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>446,650,000.00</b>	<b>107,483,081.00</b>	<b>(101,621,155.16)</b>	<b>452,511,925.84</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(8,428,963.81)	(8,428,963.81)
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>446,650,000.00</b>	<b>107,483,081.00</b>	<b>(109,772,482.47)</b>	<b>444,360,598.53</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	23,520,000.00	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	5,830,313.81	5,830,313.81
8	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>446,650,000.00</b>	<b>107,483,081.00</b>	<b>(104,219,805.16)</b>	<b>449,913,275.84</b>
9	<b>2025 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>446,650,000.00</b>	<b>107,483,081.00</b>	<b>(104,219,805.16)</b>	<b>449,913,275.84</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	6,609,517.36	6,609,517.36
11	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>446,650,000.00</b>	<b>107,483,081.00</b>	<b>(97,610,287.80)</b>	<b>456,522,793.20</b>
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	17,029,472.59	17,029,472.59
17	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>446,650,000.00</b>	<b>107,483,081.00</b>	<b>(80,580,815.21)</b>	<b>473,552,265.79</b>

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 76,893.5 мянган төгрөгийн дансны үнэтэй 33 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил илрүүлж,<sup>1</sup> цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах 1 зөвлөмж өглөө. Үүнд:

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 5.3.1. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 33 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдэл” мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

### Өгсөн зөвлөмж

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д заасны дагуу ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх, шаардлагагүй хөрөнгийг актлах, данснаас хасах зэрэг саналыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>1</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой 8 төрлийн 5,750.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй, ашиглах боломжгүй 25 төрлийн 71,153.5 мянган төгрөгийн хөрөнгийг журмын дагуу бүртгэлээс хасаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>